



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Баянгол сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/225-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.selenge@audit.gov.mn

Сүхбаатар сум
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа
Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Батмөнх
Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn
Аудитыг гүйцэтгэсэн: Их наяд аудит ХХК
Захирал: Х.Ариунзул
Утас: 99077062 Цахим хаяг: ikhnayadaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. АУДИТЫН ДҮГНЭЛТ	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	9
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	9
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
БЕГ	Боловсролын ерөнхий газар
БШУГ	Боловсрол, шинжлэх ухааны газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
МУЕА	Монгол улсын ерөнхий аудитор
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН БАЯНГОЛ
СУМЫН 1 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Ц.ОРХОНЦЭЦЭГ ТАНАА

2024.02.23 № СЭН-2024/225/НА-СТЯ-ТМЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Баянгол сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянгол сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Баянгол сумын 1 дүгээр цэцэрлэг нь Боловсролын Ерөнхий газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/324 дүгээр тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 1 дүгээр түвшинд үнэлэгдэж, нэг удаагийн тэтгэмжид 18,985.4 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 10,222.9 мянган төгрөг, нийт 29,208.3 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Тус цэцэрлэгийн мөрдөж байгаа Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа

боловсролын байгууллагын онцлогт тохирохгүй байгаа бөгөөд үр дүнд суурилсан хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн онцлогтой тохирохгүй байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд 18 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 91.5 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	93,001,912.53	169,525,728.58
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	20,863,505.83	83,976,405.88
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	20,863,505.83	83,976,405.88
3121	Төгрөг	20,863,505.83	83,976,405.88
31211	Төрийн сангийн харилцах	20,863,505.83	83,976,405.88
33	АВЛАГА	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	72,138,406.70	85,549,322.70
351	Түүхий эд материал	1,284,000.00	1,284,000.00
35130	Эм боох материал	1,284,000.00	1,284,000.00
354	Хангамжийн материал	70,854,406.70	84,265,322.70
35410	Бичиг хэргийн материал	872,250.00	2,692,250.00
35460	Хүнсний материал	3,641,848.00	914,494.00
35470	Бусад хангамжийн материал	66,340,308.70	80,658,578.70
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	825,589,210.53	839,577,523.13
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	825,589,210.53	839,577,523.13
392	Биет хөрөнгө	813,989,210.45	828,165,023.02
39201	Барилга, байгууламж, орон сууц	853,032,985.00	857,377,385.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(96,291,191.91)	(111,832,875.39)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	68,161,417.28	66,418,528.64
39206	Хуримтлагдсан элэгдэл	(49,780,816.47)	(26,925,644.63)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	59,685,051.75	48,729,131.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	(41,248,988.65)	(32,180,770.45)
39214	Бусад үндсэн хөрөнгө	26,717,301.40	30,128,801.40
39215	Хуримтлагдсан элэгдэл	(8,947,333.95)	(6,210,319.05)
39217	Ном	2,660,786.00	2,660,786.00
393	Биет бус хөрөнгө	11,600,000.08	11,412,500.11
39301	Програм хангамж	1,250,000.00	1,250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(499,999.92)	(687,499.89)
39303	Бусад биет бус хөрөнгө	10,850,000.00	10,850,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	918,591,123.06	1,009,103,251.71
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	918,591,123.06	1,009,103,251.71
51	Засгийн газрын хувь оролцоо	918,591,123.06	1,009,103,251.71
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	497,363,823.00	497,363,823.00
51101	Өмч: - төрийн	497,363,823.00	497,363,823.00
512	Хуримтлагдсан үр дүн	326,988,122.74	417,500,251.39
51210	Өмнөх үеийн үр дүн	326,988,122.74	326,988,122.74
51220	Тайлант үеийн үр дүн	-	90,512,128.65
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	94,239,177.32	94,239,177.32
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	918,591,123.06	1,009,103,251.71

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,651,430,398.30	954,757,303.69
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	919,343,925.55	24,953,664.69
120	Нийтлэг татварын бус орлого	919,343,925.55	24,953,664.69
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	70,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	3,035,000.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	19,922,794.69
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого – Үндсэн хөрөнгө	846,273,850.85	-
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого – Бараа материал	70,035,074.70	4,960,870.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	732,086,472.75	929,803,639.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	656,451,000.00	850,377,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	656,451,000.00	850,377,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	75,635,472.75	79,426,139.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	75,635,472.75	79,426,139.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	732,839,275.24	863,884,476.33
21	УРСГАЛ ЗАРДАЛ	732,839,275.24	863,884,476.33
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	714,304,175.24	844,899,076.33
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	466,953,099.45	560,961,544.29
210101	Үндсэн цалин	317,840,653.53	383,563,770.10
210102	Нэмэгдэл	109,720,909.07	142,937,530.83
210104	Урамшуулал	14,513,282.95	34,460,243.36
210105	Гэрээт ажлын хөлс	24,878,253.90	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	59,104,039.47	72,590,138.66
210201	Тэтгэврийн даатгал	41,778,720.94	49,939,139.68
210202	Тэтгэмжийн даатгал	4,431,662.51	5,875,193.01
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,511,032.12	4,590,154.30
210204	Ажилгүйдлийн даатгал	844,834.86	1,107,238.44
210205	Эрүүл мэндийн даатгал	8,537,789.04	11,078,413.23
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	46,258,007.00	60,956,139.00
210301	Гэрэл, цахилгаан	7,043,191.00	9,866,807.51
210302	Түлш, халаалт	38,491,456.00	50,365,971.49
210303	Цэвэр, бохир ус	723,360.00	723,360.00
2105	Нормативт зардал	88,444,182.00	102,501,858.00
210502	Хоол, хүнс	88,444,182.00	102,501,858.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,496,100.00	5,475,100.00
210604	Урсгал засвар	1,496,100.00	5,475,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,406,000.00	1,460,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,406,000.00	1,460,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	50,642,747.32	40,953,896.38
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,233,107.00	12,194,713.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,744,500.00	2,561,200.00

210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	33,665,140.32	26,197,983.38
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,535,100.00	18,985,400.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,535,100.00	18,985,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	18,535,100.00	18,985,400.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	918,591,123.06	90,872,827.36
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	360,698.71
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	360,698.71
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(360,698.71)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	918,591,123.06	90,512,128.65

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	735,121,472.75	929,803,639.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,035,000.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	35,000.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	35,000.00	-
122	Тусламжийн орлого	3,000,000.00	-
122001	Хандив тусламж /дотоод/	3,000,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	732,086,472.75	929,803,639.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	656,451,000.00	850,377,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	656,451,000.00	850,377,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	75,635,472.75	79,426,139.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	75,635,472.75	79,426,139.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	701,277,466.92	846,136,538.95
21	УРСГАЛ ЗАРДАЛ	701,277,466.92	846,136,538.95
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	682,742,366.92	827,151,138.95
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	466,953,099.45	560,961,544.29
210101	Үндсэн цалин	317,840,653.53	383,563,770.10
210102	Нэмэгдэл	109,720,909.07	142,937,530.83
210104	Урамшуулал	14,513,282.95	34,460,243.36
210105	Гэрээт ажлын хөлс	24,878,253.90	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	59,104,039.47	72,590,138.66
210201	Тэтгэврийн даатгал	41,778,720.94	49,939,139.68
210202	Тэтгэмжийн даатгал	4,431,662.51	5,875,193.01
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,511,032.12	4,590,154.30
210204	Ажилгүйдлийн даатгал	844,834.86	1,107,238.44
210205	Эрүүл мэндийн даатгал	8,537,789.04	11,078,413.23
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	46,258,007.00	60,956,139.00
210301	Гэрэл, цахилгаан	7,043,191.00	9,866,807.51
210302	Түлш, халаалт	38,491,456.00	50,365,971.49
210303	Цэвэр, бохир ус	723,360.00	723,360.00
2105	Нормативт зардал	88,738,905.00	99,774,504.00
210502	Хоол, хүнс	88,738,905.00	99,774,504.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,496,100.00	5,475,100.00
210604	Урсгал засвар	1,496,100.00	5,475,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,406,000.00	1,460,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,406,000.00	1,460,400.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,786,216.00	25,933,313.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,036,216.00	21,552,113.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,750,000.0	4,381,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,535,100.00	18,985,400.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,535,100.00	18,985,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	18,535,100.00	18,985,400.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	33,844,005.83	83,667,100.05
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	12,980,500.00	20,624,200.00
2200	Дотоод эх үүсвэрээр	12,980,500.00	20,624,200.00
220001	Барилга байгууламж	12,980,500.00	4,344,400.00
222001	Тоног төхөөрөмж		16,099,800.00
223001	Бусад хөрөнгө		180,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(12,980,500.00)	(20,624,200.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	20,863,505.83	63,042,900.05
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	20,863,505.83
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	20,863,505.83	83,976,405.88

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны үр дүн
А	1	2	3	4
2021 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	497,363,823.00	94,239,177.32	324,382,425.23	915,985,425.55
Тайлант үеийн үр дүн	-	-	2,605,697.51	2,605,697.51
2022 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	497,363,823.00	94,239,177.32	326,988,122.74	918,591,123.06
НББ-ийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
ҮХ-ийн өсөлт, бууралт	-	-	-	-
ҮХ-ийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	90,512,128.65	90,512,128.65
2023 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	497,363,823.00	94,239,177.32	417,500,251.39	1,009,103,251.71

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	796,910,700.00	729,272,922.61	67,637,777.39	91.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	796,910,700.00	729,272,922.61	67,637,777.39	91.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	796,910,700.00	729,272,922.61	67,637,777.39	91.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	564,247,100.00	508,123,966.26	56,123,133.74	90.1
210101	Үндсэн цалин	379,363,300.00	356,546,544.06	22,816,755.94	94.0
210102	Нэмэгдэл	167,531,900.00	135,430,737.21	32,101,162.79	80.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт			-	
210104	Урамшуулал	17,351,900.00	16,146,684.99	1,205,215.01	93.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	76,414,300.00	68,640,711.35	7,773,588.65	89.8
210201	Тэтгэврийн даатгал	51,961,300.00	47,153,286.69	4,808,013.31	90.7
210202	Тэтгэмжийн даатгал	6,113,300.00	5,544,030.54	569,269.46	90.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,890,800.00	4,378,225.46	512,574.54	89.5
210204	Ажилгүйдлийн даатгал	1,222,700.00	1,050,980.79	171,719.21	86.0
210205	Эрүүл мэндийн даатгал	12,226,200.00	10,514,187.87	1,712,012.13	86.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	72,045,400.00	72,045,400.00	-	100.0
210301	Гэрэл, цахилгаан	7,484,420.04	7,484,420.04	-	100.0
210302	Түлш, халаалт	64,260,979.96	64,260,979.96	-	100.0
210303	Цэвэр, бохир ус	300,000.00	300,000.00	-	100.0
2105	Нормативт зардал	59,610,400.00	55,904,405.00	3,705,995.00	93.8
210502	Хоол, хүнс	59,610,400.00	55,904,405.00	3,705,995.00	93.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,470,000.00	3,470,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	3,470,000.00	3,470,000.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,262,600.00	1,240,100.00	22,500.00	98.2
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,262,600.00	1,240,100.00	22,500.00	98.2
210807	Газрын төлбөр			-	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,860,900.00	19,848,340.00	12,560.00	99.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,073,100.00	16,060,540.00	12,560.00	99.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,787,800.00	3,787,800.00	-	100
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	796,910,700.00	768,209,500.00	28,701,200.00	96.3

	Улсын төсвөөс санхүүжих	692,694,100.00	692,694,100.00		100.0
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	75,515,400.00	75,515,400.00	-	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	75,515,400.00	75,515,400.00	-	100.0
	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	28,701,200.00	-	-	-
	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	28,701,200.00	-	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	28,701,311.90	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	67,637,889.29	-	-
1	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО				100.0
3	Төсвийн байгууллага	1.00	1.00		100.0
4	Төсвөөс гадуур байгууллага				
5	АЖИЛЛАГСАДЫН ТОО	33.00	33.00		100.0
6	Удирдах ажилтан	1.00	1.00		100.0
7	Гүйцэтгэх ажилтан	23.00	23.00		100.0
8	Үйлчлэх ажилтан	9.00	9.00		100.0
10	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	260.00	260.00		100.0
14	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА				
15	Төрийн өмчит СӨБ байгууллага				

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Баянгол сумын 1 дүгээр цэцэрлэг нь “Хүүхэд бүрийн авьяас, сонирхол, хувь шинжийг нээдэг, түүнийг хөгжүүлдэг, дэмждэг, хүүхэд нэг бүртээ ажилладаг арга зүй, технологи, зохион байгуулалтыг бий болгоход чиглэсэн орчныг бүрдүүлнэ” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сургуулийн өмнөх насны хүүхэд цэцэрлэгтээ айдасгүй, амар тайван суралцаж суралцахуйн хоцрогдолгүйгээр эрүүл аюулгүй тэгш хүртээмжтэй орчинд сурч хөгжих боломжийг бүрдүүлэх,

- Сургалтын байгууллагын болон багшийн ажлын гүйцэтгэлд суурилан тасралтгүй хөгжих олон хэлбэрт үйл ажиллагаанд хамрагдах,
- Багш ажилтан бүр ёс зүйн хэм хэмжээ шаардлагыг мөрдөж төсвийг төлөвлөх, үр ашигтай зарцуулахад идэвх санаачилгатай ажиллах,
- Багш нар технологийн дэвшлийг ашиглан орон зайнаас үл хамааран ээлжит хичээлийн цахим контентын сан бүрдүүлэн бүтээлчээр ашиглах,
- Мэргэжлийн хөгжлийн бүлэгтээ хамтран ажиллах зөвлөх, тэргүүлэх багшийн манлайлал үүрэг оролцоог нэмэгдүүлэх.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,*
- *Боловсролын ерөнхий хууль 2023 оны 07 дугаар сарын 07-нд шинэчлэн батлагдсан,*
- *Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон,*
- *БШУС-ын 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 1/2714 тоот албан бичгээр боловсролын байгууллагын төсвийн шинэчлэлийн хүрээнд: "Цэцэрлэгт шаардлагатай хүүхдийн тоглоом, наадгай, зөөлөн эдлэл ханган нийлүүлэх, худалдан авах ажиллагааг зохион байгуулах" чиглэлийг хүргүүлсэн гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд БШУЯ-ны Хяналт, шинжилгээ үнэлгээний газрын Дотоод аудитын хэлтсээс хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянгол сумын 1 дүгээр цэцэрлэг нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сэлэнгэ аймгийн Баянгол сумын 1 дүгээр цэцэрлэг нь 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 1,009,103.3 мянган төгрөг болж өмнөх оноос 90,512.1 мянган төгрөгөөр буюу 9.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	20,863.5	83,976.4	63,112.9
Авлага	-	-	-
Бараа материал	72,138.4	85,549.3	13,410.9
Үндсэн хөрөнгө	825,589.2	839,577.5	13,988.3
Нийт хөрөнгө	918,591.1	1,009,103.3	90,512.1
Өр төлбөр	-	-	-

Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	918,591.1	1,009,103.3	90,512.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	918,591.1	1,009,103.3	90,512.1

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн данс 83,976.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 7.9-д заасны дагуу тайлант жилийн үйл ажиллагааны зардлын хэмнэлтийг төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнасангай холбоотой байна.
- Бараа материалын дансны үлдэгдэл 85,549.3 мянган төгрөг болж 13,410.9 мянган төгрөгөөр өссөн нь 1,000.0 мянган төгрөгийн бараа материалыг хандиваар, БШУГ-аас 3,960.9 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүйгээр, төсвийн хөрөнгөөр 121,738.6 мянган төгрөгийн бараа материал худалдан авч 113,288.5 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас шалтгаалсан байна.
- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 839,577.5 мянган төгрөг болж 13,988.3 мянган төгрөгөөр өссөн нь элэгдлээрээ өртгөө нөхсөн хөрөнгийг дахин үнэлж бүртгэснээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 591,474.4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 75,515.4 мянган төгрөг, нийт **666,989.8** мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас нийт **129,920.9** мянган төгрөгийн орлого эх үүсвэрийг нэмэгдүүлэн тооцож улсын төсвөөс 692,694.1 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвөөс 75,515.4 мянган төгрөгөөр, урьд оны дансны үлдэгдлээс 28,701.2 мянган төгрөгийг төвлөрүүлэн нийт **796,910.7** мянган төгрөгийг зарцуулахаар баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 15 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 692,694.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 75,515.4 мянган төгрөг, урьд оны санхүүжилтээс 28,701.2 мянган төгрөг нийт **796,910.7** мянган төгрөгийн эх үүсвэрийг урсгал үйл ажиллагаанд захиран зарцуулахаар төлөвлөсөн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **729,272.9** мянган төгрөг буюу 91.5 хувьтай байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардлыг 56,157.9 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 7,773.6 мянган төгрөгөөр, хоолны зардлыг 3,706.3 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

							/мянган төгрөгөөр/	
д/д	Хөтөлбөр	д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт	
1	71801 Сургуулийн өмнөх боловсрол	1	81605- Эрүүл мэндийг дэмжих	1,908.9	1,908.9	-	100.0	
		2	81807- Цэцэрлэгийн хүүхдийн хоол	59,610.4	55,904.4	3,706.0	93.9	
		3	81816- Зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр	2,991.7	2,991.7	-	100.0	
		4	81823- Боловсролын байгууллагын багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх	1,893.9	1,893.9	-	100.0	
		5	81834- Боловсролын стандарт сургалт	496,619.4	455,001.1	41,618.3	91.6	
		6	81835- Сургалтын хэвийн үйл ажиллагаа	158,371.0	136,057.5	22,313.5	85.9	
		7	80111- Төрийн өмчийн байгууллагын тогтмол зардал	75,515.4	75,514.4	-	100.0	
Нийт				796,910.7	729,272.9	67,637.8	91.5	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Баянгол сумын 1 дүгээр цэцэрлэг нь 2023 онд улсын төсвийн хөрөнгөөр хүүхдийн хоол хүнс худалдан авах 59,610.4 мянган төгрөг төсөв батлагдсан байна.

Тайлант онд худалдан авах ажиллагааны урилгыг tender.gov.mn цахим сайтад байршуулж, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан байна. Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааны шалгаруулалтад "Хүүгийн хишиг" ХХК оролцож, гүйцэтгэгчээр шалгаран гэрээ байгуулан, худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Баянгол сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Их наяд аудит” ХХК-ийн аудитор Х.Ариунтуяа гүйцэтгэж, хяналтыг захирал Х.Ариунзул, дараагийн шатны хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сэлэнгэ аймгийн Баянгол сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Их наяд аудит” ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатны материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 732,839.3 мянган төгрөгөөс 1,0 хувиар буюу 7,328.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Баянгол сумын 1 дүгээр цэцэрлэг нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан *“Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”*-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Баянгол сумын 1 дүгээр цэцэрлэг нь шилэн дансны нэгдсэн системд мэдээлбэл зохих 28 төрлийн 159 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Бусад хууль тогтоомжтой холбоотой асуудал

Тайлант онд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хамаарах алдаа, зөрчил илрээгүй.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны 123 дугаар *“Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай”* албан бичгийг хүргүүлсэн бөгөөд 2023 оны санхүүгийн тайлангийн завсрын аудитаар 94,485.3 мянган төгрөгийн 6 алдаа илэрсэн байна. Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчлийн хэрэгжилтийг шалгахад алдааг залруулж, зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 4,432.8 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 4,432.8 мянган төгрөгийн 1 албан шаардлага, зөрчлийг арилгах давтан гаргахгүй ажиллах 1 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

Аудитаар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 100 хувийн биелэлттэй байна.

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	1	4,432.8	1	4,432.8	100.0
Зөвлөмж	1	-	1	-	100.0
Нийт дүн	2	4,432.8	2	4,432.8	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараах асуудлыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1. Дээд шатны төсөв захирагчаас төсвийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Иймд төсвийг бодит гүйцэтгэлтэй нь уялдуулан зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөж, зарцуулан гүйцэтгэж байх шаардлагатай байна.

2. Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан үндсэн хөрөнгийн тооллого хийж, биет тест хэрэгжүүлэх горимыг бүрэн хэрэгжүүлээгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 68,601.5 мянган төгрөгийн 6 алдааг¹ залруулав. Үүнд:

1. Тооцооны дансны бүртгэлийг хөтлөхдөө харилцагчийн нэрийг буруу сонгосноос өр төлбөрийн данс 4,717.8 мянган төгрөгийн зөрүүтэй илэрхийлэгдсэн байна.
2. Үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгөөр бүртгэх 19,922.8 мянган төгрөгийн хөрөнгийг дахин үнэлгээний орлогоор бүртгэж тайлагнасан байна.
3. Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас 32,633.1 мянган төгрөгийн цахим баримтгүй худалдан авалтыг гүйцэтгэсэн бүрдүүлсэн.
4. Цалингийн зардал, түүнтэй холбоотой 4,615.9 мянган төгрөгийн ажил гүйлгээг журналд мөнгөн сууриар бүртгэж, тайлагнасан.
5. Журналд НДШ-ийн зардлыг 6,201.9 мянган төгрөгөөр зөрүүтэй тусгаж тайлагнасан.
6. Авлага, өр төлбөрийг журналд тусгахдаа харилцагчийн нэрийг буруу сонгож илүү дутуу илэрхийлсэн байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Аудитаар нийт 2,703.9 мянган төгрөгийн 2 зөрчил² илрүүлж, зөвлөмж хүргүүллээ.

5.1. Зөвлөмж

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Төлбөр тооцоог урьдчилан хянан баталгаажуулаагүйн улмаас нийгмийн даатгалын шитгэлийн тайланд 2,703.9 мянган төгрөгийн цалинг дутуу тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 32 дугаар зүйлийн 2 дахь "Ажил олгогч орон тоо болон цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүнийг үнэн зөв тодорхойлж, ...нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан, мэдээг гарган энэ хуулийн 25.1-д заасан хугацаанд нийгмийн даатгалын байгууллагад хүргүүлэх үүрэг хүлээнэ" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Төлбөр тооцоог урьдчилан хянан баталгаажуулж, бодогдсон цалинг НДШ-ийн тайланд үнэн зөв тусгаж тайлагнах.

2. Балансын данстай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 67 нэр төрлийн нийт 51,034.4 мянган төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг шийдвэрлэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй.

Энэ нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1 "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн ТӨБЗГ-т ирүүлж шийдвэрлүүлнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ өртгөө нөхсөн, ашиглаж байгаа үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэн шийдвэрлүүлэх, хөрөнгөд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5³ дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

³ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Өр төлбөрийн дансыг зөрүүтэй илэрхийлсэн	1	4,717.8			1	4,717.8	1	4,717.8				
Үндсэн хөрөнгийн орлогыг буруу бүртгэн тайлагнасан	1	19,922.8			1	19,922.8	1	19,922.8				
Цахим баримтгүй худалдан авалт гүйцэтгэсэн	1	32,633.1			1	32,633.1	1	32,633.1				
Цалингийн зардлыг журналд мөнгөн сууриар хөтөлж, бүртгэсэн	1	4,615.9			1	4,615.9	1	4,615.9				
НДШ-ийн зардлыг журналд зөрүүтэй тайлагнасан	1	6,201.9			1	6,201.9	1	6,201.9				
Авлага, өр төлбөрийг журналд тусгахдаа харилцагчийн нэрийг буруу сонгож илүү дутуу илэрхийлсэн байна	1	-			1	-	1	-				
Дүн	6	68,091.5			6	68,091.5	6	68,091.5	6	68,091.5		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
НДШ-ийн тайланд цалин дутуу тайлагнасан.	1	2,703.9			1	2,703.9				
Элгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 67 нэр төрлийн нийт хөрөнгийг шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллаагүй.	1	-			1	-				
Дүн	2	2,703.9			2	2,703.9				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс				Зөвлөмж	
	Төлбөрийн акт		Албан шаардлага					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								